



Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
төр л халгийн
тогтвортой оршдог.

Аристотель

Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2023.06.30

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ XI болон XII БОТЬ ХЭВЛЭГДЛЭЭ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ
ИЙН ЭМХЭТГЭЛ
XI БОТЬ

СУДАЛГААНЫ
ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ
XII БОТЬ

Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгаа



Улаанбаатар хот
2022 он



хот



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬЧДЫН ӨДӨР

2023.06.25-ны өдөр
ТОХИОЛОО



ЮНЕСКО-ИЙН ДЭРГЭДЭХ ИНФОТЕРМИЙН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН 24 ДҮГЭЭР ЧУУЛГАН БОЛЛОО

2023 оны 05 дугаар сарын зүйн үндэсний хүрээлэнгийн “Инфотерм” буюу олон улсын 31-ний өдөр Олон улсын захирал, Хууль зүйн ухааны нэр томъёоны мэдээллийн нэр томъёоны мэдээллийн доктор (Dr. Jur) Х.Эрдэм-төвийг ЮНЕСКО-оос төв болох “Инфотерм”-ийн Ундрах оролцож, 2023 оны 1971 онд нэр томъёоны Ерөнхий Ассамблейн 24 5 дугаар сарын 04-ний өдөр салбарт олон улсын дүгээр чуулган онлайнаар нэмэлт өөрчлөлт орсон хамтын ажиллагааг дэмжих зохион байгуулагдлаа. Хууль тогтоомжийн тухай зорилгоор байгуулж байжээ. Чуулганаар 2022 онд хуулиар Хууль зүйн үндэсний Энэ удаагийн чуулганд Инфотермээс болон хүрээлэнгийн дэргэд Хууль Инфотермийн удирдах гишүүн орнуудаас хийж зүйн хэлний зөвлөл ажиллах зөвлөлийн гишүүд болон хэрэгжүүлсэн ажил, арга болсон тухай, эрх зүйн Монгол, ХБНГУ, БНСУ, хэмжээ, 2023 онд хэрэгжүүлэх мэдээллийн нэгдсэн систем Австри, Аргентин, Польш, үйл ажиллагааны төлөвлөгөө, www.legalinfo.mn цахим Колумб, Испани, Итали, санхүүгийн аудитын дүгнэлт хуудасны үйл ажиллагаа, Иран, Гүрж, Литва зэрэг орны зэргийг хэлэлцүүлсэн болно. хөгжүүлэлт, Хууль зүйн төлөөлөл оролцлоо. Монгол нэр томъёоны уламжлал, улсаас Хууль зүйн үндэсний Хууль зүйн үндэсний хүрээлэн хувьслын асуудлаар хүрээлэнгийн захирал, нь 2022 онд Олон улсын нэр эрдэм шинжилгээний Хууль зүйн ухааны доктор томъёоны мэдээллийн төвийн хурлыг уламжлал болгон (Dr. Jur) Х.Эрдэм-Ундрах, гишүүнээр элссэн. Энэ зохион байгуулдаг ШУА-ийн Хэл зохиолын удаагийн чуулганд гишүүн талаар танилцууллаа. хүрээлэнгийн захирал, доктор байгууллагын хувьд Хууль Н.Мөнхцэцэг нар оролцов.




**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

*Info
term*

ГАМШГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЛТ БОЛЛОО

Үндэсний аюулгүй байдлын зохион байгууллаа. ерөнхий боловсролын зөвлөл, Шадар сайдын сургууль, цэцэрлэгийн ажлын алба, Онцгой байдлын Хууль зүйн үндэсний бэлэн байдлыг хангуулах, ерөнхий газар, Нийслэлийн хүрээлэнгийн албан хаагчид нийслэл хотод суурилуулсан Засаг даргын тамгын газар гамшгийн аюулын дохиогоор төвлөрсөн зарлан мэдээлэх хамтран анх удаагаа зохион Хуульчдын талбайн аюулгүйн хэрэгслийн бэлэн байдал байгуулж байгаа Стратегийн цугларах цэгт цуглаж, дадлага үйлчлэх хүрээг шалгах, команд штабын сургуулийн сургуулилтад оролцов. иргэдийг гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх хүрээнд өнөөдөр 16:00 дохиогоор ажиллуулж цагт орон даяар гамшгийн сургах ач холбогдолтой юм. аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор тулгарсан үед төрийн болон ажиллах дадлага сургуулилт төрийн бус байгууллага,



ШУА-ИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА




Хууль зүйн үндэсний хүрээлэн ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Тус санамж бичиг нь Монгол хэлний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

Санамж бичигт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор

Ж.Бат-Ирээдүй нар гарын үсэг зурлаа. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн доктор Г.Давааням, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор О.Шинэбаяр, тус хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор Н.Мөнхцэцэг нар байлцав.



“ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ: СОЛОНГОС БА МОНГОЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Зүүн хойд Ази дахь Үндсэн хуулийн шүүх: Солонгос ба Монгол” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал боллоо.

Уг эрдэм шинжилгээний хурлыг ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, ОУУБИС-ийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэн болон БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн судалгааны хүрээлэн тус тус хамтран зохион байгуулсан

бөгөөд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригнээж, хурлынцаг үеэ олсон байдлыг тодотгов.

Хуралд Монгол талаас Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, ОУУБИС-ийн Монгол-Солонгосын хүрээлэнгийн захирал О.Амарсанаа, Солонгос талаас БНСУ-ын Үндсэн

хуулийн шүүхийн судалгааны хүрээлэнгийн захирал И Хон Хван, мөн судлаач Хан Дун Хүн, Ажү Ис-ийн профессор Чон Гён Гин нар илтгэл тавьж, хэлэлцүүлээ.

Хурлын хаалтын үгэндээ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Давааням Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтыг сайжруулах БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн туршлага чухал болохыг онцлов.



БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ МЭДҮҮЛГЭЭ ИРҮҮЛЭХИЙГ УРЬЖ БАЙНА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Хууль зүй, дотоод хэргийн яам нь Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах -ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2023 оны 07 -р сарын 17 -ны өдрийн 17 цаг 00 минут хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр **2023 оны 07 -р сарын 21 -ны өдрийн 15 цаг 00 минут-ны дотор** ирүүлнэ үү.



Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах “Хууль зүй, дотоод хэргийн яам” нь дээрх зөвлөх үйлчилгээг үзүүлэх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах

мэдээллийг ирүүлнэ.

1. Б а й г у у л л а г ы н ерөнхий танилцуулга

2. Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхийн талаар мэдээлэл /Ажлын даалгаварт заасны дагуу/

3. Сүүлийн 3 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэгчээр ажилласан

туршлагын мэдээлэл /Ажлын даалгаварт заасны дагуу/ болно.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Манай аав зохиолч хүн байсан юм. Би аавынхаа зохиолыг өвлөн авч болох уу?

Болно. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15.1-д зааснаар Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилна. Иймд та өвлөх эрхийн гэрчилгээ гарсны дараа Оюуны өмчийн газарт хандан тэмдэглэгээ үйлдүүлнэ.

Хууль зүйн мэдээлэл, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 47

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Тухайн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалагдсаныг хэрхэн мэдэх вэ?

Бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх хамгаалагдсаныг илэрхийлэх таних тэмдэг хэрэглэх эрхтэй. Үүнд:

- Дугуй хүрээ бүхий латин "C" үсэг буюу ©;
- Бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэр;
- Бүтээлийг анх нийтэлсэн оноо.

Хууль зүйн мэдээлэл, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 48

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Би цахим сүлжээнд нэрээ нууцлан нийтлэл оруулах бодолтой байгаа юм. Энэ нь боломжтой юу?

Болно. Зохиогч бүтээлийнхээ хувьд бүтээлээ өөрийн болон зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтлэх амины эрхийг эдэлнэ. Зохиомол, нууц нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, задруулахыг хориглоно.

Хууль зүйн мэдээлэл, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 49

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Зохиогчийн эрхийг зөрчсөн хүнд ямар хариуцлага тооцох вэ?

Зөрчлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Зохиогчийн эрхийн тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5,000,000 төгрөгөөр торгоно.

Хууль зүйн мэдээлэл, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 50

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Энэ жил Үндэсний их баяр наадмаар хэдэн хоног амрах вэ?

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт зааснаар "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр, 07 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд тус тус амрахаар заасан тул ажлын 5 өдөр амарна.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛАТ, ХАРИУАЛ ЦУВРАЛ 42

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хөдөлмөрийн тухай хуульд 07 дугаар сарын 10-ны өдөр амрахгүй байхаар хуульчилсан ч Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд 07 дугаар сарын 10-нд амрахаар хуульчилсан байна. Аль хуугийг нь дагаж мөрдөх вэ?

Хөдөлмөрийн тухай хуулийн 2.5 дахь хэсэгт зааснаар "...хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдөөл ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ" гэж заасан тул Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд зааснаар 07 дугаар сарын 10-ны өдөр бүх нийтээрээ амрах нь хууль зүйн үндэслэлтэй.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛАТ, ХАРИУАЛ ЦУВРАЛ 43

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдөр нийтээр амрах өдөр үү, тэмдэглэлт өдөр үү?

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.15 дахь хэсэгт зааснаар жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдөр нь "Монгол Улсын төрийн далбааны өдөр" тул тэмдэглэлт баярын өдөр бөгөөд бүх нийтээр тэмдэглэх баярын өдөртэй давхцаж болдог.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛАТ, ХАРИУАЛ ЦУВРАЛ 44

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ

"Нийтээр тэмдэглэх баярын өдөр" болон "Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр" ямар ялгаатай вэ?

"Нийтээр тэмдэглэх баярын өдөр" гэдэг нь улс орны хэмжээнд нийтээр амарч, баяр болгон тэмдэглэдэг өдрийг хэлэх бол "нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр" гэж түүхэн болон тодорхой үйл явдалтай холбоотой, нийгмийн тодорхой давхаргыг хамарсан, бүх нийтээр тэмдэглэж заншсан, улс орны хэмжээнд нийтээр амрахгүй өдрүүдийг хэлнэ.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛАТ, ХАРИУАЛ ЦУВРАЛ 45

Иргэн танд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг энгийн утасны тарифаар хүргэх утас:

1800-1202

